

Сэдэв: Шүлэг, яруу найраг

Дараах зохиолчийн намтар болон шүлгийг уншаад, даалгаврыг гүйцэтгээрэй.



ЗАГДЫН ТҮМЭНЖАРГАЛ (1953-2012)

Төрсөн нутаг: Төв аймгийн Угтаалцайдам сумын нутагт төржээ.

Гол уран бүтээл: "Үүрийн тэнгэр", "Арван найман нас минь", "Уяхан цэнхэр хавар", "Ус мөрөн олон чиг" зэрэг яруу найргийн түүвэр хэвлүүлжээ.

"Бага насаа би хайрлаж явна", "Бөөн баяр", "Арван найман нас", "Цэцгэн зүйрлэл", "Монголын тал нутаг", "Ус мөрөн олон чиг", "Уяхан цэнхэр хавар" зэрэг 200 гаруй дууны шүлэг бичжээ.

Зохиолчийн хэлсэн онцлох үг: Ухааны жигүүр эрт өдөлбөл
Уужуу орчлонд хоёр амьдарсны адил аа...

Уншихдаа

Сэтгэлдээ төсөөлөн бодоорой.

МОНГОЛЫН ТАЛ НУТАГ

Дүүжүү алсаас ирээд
Дүүрэн амьсгаа авахад минь
Мөнхийн уснаас амсах шиг
Цээж дүүрэн цэлмээд
Ямар цэнгэг юм бэ?
Монголын ариун агаар
Яасан цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр
Алман цагаан саран
Тормос тормос мишээгээд
Алтан мөнгөн одод нь
Тодрон тодрон жирвэлзээд
Ямар цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр
Яасан цэнгэг юм бэ?
Монголын ариун агаар

Аяны шувуудын цуваа
Алжаан цуцаж гатлаад
Алаг нүдний үзүүрт
Хаяа хязгааргүй цэлийгээд
Ямар уудам юм бэ?
Монголын тал нутаг
Яасан уужуу юм бэ?
Монгол хүний сэтгэл
Уруудах өөдлөх тавиланд
Сэтгэлийн цавгүй амгалан
Учрах ханилах заяанд
Итгэлийн сэвгүй цайлган
Ямар уужуу юм бэ?
Монгол хүний сэтгэл
Яасан уудам юм бэ?
Монголын тал нутаг

(З.Түмэнжаргал, "Гэрэл гэгээний хүлэг морин мэт". УБ., 2007. 204 дүгээр тал)

1. Дараах үгийн утгыг тайлбарлаарай. Зөв харгалзуулна уу.

- | | |
|-----------|---------------------------------|
| 1. дүүжүү | a) ядрах, цуцах |
| 2. алжаах | b) ямар нэгэн гэм хор суугаагүй |
| 3. цавгүй | c) ан, завсар гараагүй |
| 4. сэвгүй | d) нэн хол |

A. 1c2a3b4d
B. 1d2a3b4c

C. 1a2b3c4d
D. 1d2a3c4b

2. Шүлгийн бадаг бүрд юуны тухай өгүүлснийг тодорхойлоорой. Зөв хариултыг тодорхойлно уу.

- | | |
|--------------|---------------------------------|
| 1. 1-р бадаг | a) Монгол хүний сэтгэлийн тухай |
| 2. 2-р бадаг | b) Монголын тал нутгийн тухай |
| 3. 3-р бадаг | c) Монголын тэнгэрийн тухай |
| 4. 4-р бадаг | d) Монголын агаарын тухай |

A. 1d2c3b4a
B. 1a2b3c4d

C. 1d2a3c4b
D. 1c2d3a4b

3. Уг шүлэгт бүхэлдээ юуны тухай өгүүлсэн бэ?

- A. Монголын агаар цэлмэг тухай
B. Монголын тэнгэр цэлмэг тухай
C. Монголын тал нутаг уудам тухай
D. Монгол хүн уужуу тухай
E. Монгол эх орон бол гайхамшиг тухай

4. Зохиолч хол газраас ирээд монголынхоо агаарыг, тэнгэрийг, газар нутгийг, монгол хүнийг яаж яаж мэдэрснийг тодорхойлоорой.

- | | |
|--------------|------------|
| 1. Агаар | a) Харах |
| 2. Тэнгэр | b) Сонсох |
| 3. Тал нутаг | c) Амтлах |
| 4. Хүн | d) Хүртэх |
| | e) Үнэрлэх |

- | | |
|-----------------|----------------|
| A. 1a2b3d4e | C. 1cde2a3ad4d |
| B. 1cd2ae3ad4ab | D. 1ed2cb3a4cd |

5. Зохиолч алс холоос ирэх үеийн эх нутгаараа бахархсан, эх нутгаа биширсэн, шүтсэн сэтгэлийн өнгө аясаа илэрхийлсэн хэлний арга хэрэглүүрийг тодорхойлоорой.

- | | |
|--|---|
| 1. Мэдрэмжээ дүрслэх аргаар | a) Яасан цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр
Ямар цэлмэг юм бэ?
Монголын хөх тэнгэр,
Тодрон тодрон жирвэлзээд ... |
| 2. Гайхан биширсэн яруу асуултын ур маягаар | b) Мөнхийн уснаас амсах шиг, цээж дүүрэн цэлмэх, тодрон тодрон |
| 3. Хэтрүүлэх, амьдчилах зэрэг уран дүрслэх арга хэрэглүүрээр | c) Мөнхийн уснаас амсах шиг, тормос тормос мишээх сар, хаяа хязгааргүй тал ... |
| 4. Уран давталтын арга хэрэглүүрээр | d) Ямар ... юм бэ? Яасан ... юм бэ? |

- | | |
|-------------|-------------|
| A. 1c2d3a4b | C. 1c2a3b4d |
| B. 1b2d3c4a | D. 1d2c3b4a |

6. Тэнгэрийн тунгалаг, цэлмэг гэснийг сар тормос тормос мишээгээд, од тодрон тодрон жирвэлзээд гэж дүрсэлсэн бол монголын газар нутаг агуу уудам, том гэдгийг ямар ямар үг хэллэгээр илэрхийлснийг олоорой.

- A. Дүүрэн амьсгаа авах
- B. Цээж дүүрэн цэлмэх
- C. Шувууд ядарч цуцаж гатлаад
- D. Алаг нүдний үзүүрт хаяа хязгааргүй цэлийгээд

7. Шүлгийн бадаг бүрийн гол утгыг илэрхийлсэн түлхүүр өгүүлбэрээр зохиолын гол санааг дүгнээрэй.

- | A. | B. | C. |
|-------------------|-------------------|---------------|
| Монгол- | Монгол – | Монгол - |
| Дүүжүү алс | Ариун агаар | Цэнгэг агаар |
| Дүүрэн амьсгаа | Алман саран | Цэлмэг тэнгэр |
| Аяны шувууд | Алтан мөнгөн одод | Уудам тал |
| Алаг нүдний үзүүр | Амгалан хүн | Уужуу хүн |

8. Уг шүлэгт аялгуу хийж дуу болгосон. Шүлгийг уншаад, дууг сонсоод төрсөн сэтгэдлээ 60 орчим үгэнд багтаан бичээрэй.